ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХАНХ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 29 өдөр Дугаар 28 Турт

г Ундны ус хогийн үнэ тогтоох тухай ¬

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1.1.2-ын г Хог хаягдлын тухай хуулийн 8.1.2.4 дэхь заалтыг үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь.

1.Сумын ундны усны үнийг 1 л тутамыг 5 төгрөгөөр усан санд тээвэрлэж иргэдэд 10 төгрөгөөр,1шуудай хогийг 500 төгрөгөөр,поошик хогийг 2000 төгрөгөөр ,1 фортер хогийг 20,000 төгрөгөөр дуудлагаар үйлчлэхэд үнийг нэмж төлөхөөр тогтоосугай.

2. Хог хаягдлын журмыг хавсралтаар баталсугай.

2.Ундны болон хогийн үнэ тогтоосон тогтоолыг 2017 оны 11 дүгээр сарын 29 ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг сумын Засаг дарга Б.Эрдэнэбаатар-д үүрэг болгосугай.

3. Усан санд ундын усыг тээвэрлэхэдээ ариун цэврийн шаардлагыг ханган иргэдэд чирэгдэлгүй үйлчилж ажиллахыг жолооч Г.Жаргал ус сангийн түгээгч нарт даалгасугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын ИТХ-ын тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА Л.ДУЛАМХҮҮ

4123083 ГСҮ0102

C:\Users\User\Downloads\ИТХ-ын-тогтоол-2017.

Ханх сумын ИТХ- ын 2017 оны ..-р сарын ... – ны

өдрийн ..... дугаар тогтоолын..... дугаар хавсралт

ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАХ, ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ, САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Зорилго

1.1 Энэхүү журмын зорилго нь байгаль орчны бохирдлыг багасгах, урьдчилан сэргийлэх үүднээс иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагаас гарах хог хаягдлыг анхан шатны эх үүсвэр дээр нь ангилан ялгах, цуглуулах, дахин боловсруулах замаар эргүүлэн ашиглах, хог хаягдлын хэмжээ, хогийн цэг талбайг багасгах, тээвэрлэн устгах, төвлөрсөн хогийн цэг талбайд засвар үйлчилгээ хийх, тэдгээртэй холбогдон гарах хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэх, зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Ханх сумын ЗДТГ, хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дарж булах, устгах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь уг журмын хүрээнд ажиллаж суманд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд дагаж мөрдөнө.

Хоёр. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийтлэг үүрэг

2.1 **Сумын засаг даргын эрх. үүрэг:**

2.1.1 Хогны менежментийн ажлын хэсэг байгууллах

2.1.2 Аймгийн Засаг даргын захирамжаар баталсан нийтийн цэвэрлэгээний өдөр /сар бүрийн эхний долоо хоногийн баасан, бямба гариг/-аар бүх нийтийг хамарсан цэвэрлэгээг тогтмол зохион байгуулж хэвшүүлэх.

2.1.3 Хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хуваарийг батлах, хяналт тавих.

2.1.4 Хог хаягдлын төвлөрсөн цэгийг тохижуулах, дахивар хогийг боловсруулах цэгийг байгуулах, хог хаягдлыг дарж булахад шаардлагатай зардлыг орон нутгийн төсөвт суулгах.

2.1.5 Хог хаягдлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй техник хэрэгслүүдийг журмын дагуу ашиглах

2.1.6 Хог хаягдлын тайлан мэдээг 6, 12 дугаар сарын 20-ны дотор гарган аймгийн Байгаль орчны газарт хүргүүлэх, улсын нэгдсэн мэдээллийн санд оруулах.

2.1.7 Эм, эмнэлгийн байгууллага болон барилга, батлан хамгаалахын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудыг хог хаягдлаа тухайн чиглэлээр мөрдөгдөж байгаа журмын дагуу устгахыг шаардах , хяналт тавих.

2.1.8 Байгальд ээлтэй, хаягдал бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих, урамшуулах

2.1.9 Аюултай хог хаягдлыг түр байршуулах газрыг байгаль орчин, эрүүл мэндийн зэрэг холбогдох мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийг үндэслэн тогтоож, түр хадгалах байр, түүнийг тээвэрлэх зам маршрут гарган батлах.

2.1.10 Гэр хороололд болон хог хаягдал хадгалах зориулалтын байгууламжгүй орон сууцанд оршин суугч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал хадгалах түр цэг тогтоох.

Ханх сумын ИТХ- ын 2017 оны ..-р сарын ... – ны

өдрийн ..... дугаар тогтоолын..... дугаар хавсралт

ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАХ, ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ, САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Зорилго

1.1 Энэхүү журмын зорилго нь байгаль орчны бохирдлыг багасгах, урьдчилан сэргийлэх үүднээс иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагаас гарах хог хаягдлыг анхан шатны эх үүсвэр дээр нь ангилан ялгах, цуглуулах, дахин боловсруулах замаар эргүүлэн ашиглах, хог хаягдлын хэмжээ, хогийн цэг талбайг багасгах, тээвэрлэн устгах, төвлөрсөн хогийн цэг талбайд засвар үйлчилгээ хийх, тэдгээртэй холбогдон гарах хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэх, зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Ханх сумын ЗДТГ, хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дарж булах, устгах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь уг журмын хүрээнд ажиллаж суманд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд дагаж мөрдөнө.

Хоёр. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийтлэг үүрэг

2.1 **Сумын засаг даргын эрх. үүрэг:**

2.1.1 Хогны менежментийн ажлын хэсэг байгуулах

2.1.2 Аймгийн Засаг даргын захирамжаар баталсан нийтийн цэвэрлэгээний өдөр /сар бүрийн эхний долоо хоногийн баасан, бямба гариг/-аар бүх нийтийг хамарсан цэвэрлэгээг тогтмол зохион байгуулж хэвшүүлэх.

2.1.3 Хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хуваарийг батлах, хяналт тавих.

2.1.4 Хог хаягдлын төвлөрсөн цэгийг тохижуулах, дахивар хогийг боловсруулах цэгийг байгуулах, хог хаягдлыг дарж булахад шаардлагатай зардлыг орон нутгийн төсөвт суулгах.

2.1.5 Хог хаягдлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй техник хэрэгслүүдийг журмын дагуу ашиглах

2.1.6 Хог хаягдлын тайлан мэдээг 6, 12 дугаар сарын 20-ны дотор гарган аймгийн Байгаль орчны газарт хүргүүлэх, улсын нэгдсэн мэдээллийн санд оруулах.

2.1.7 Эм, эмнэлгийн байгууллага болон барилга, батлан хамгаалахын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудыг хог хаягдлаа тухайн чиглэлээр мөрдөгдөж байгаа журмын дагуу устгахыг шаардах , хяналт тавих.

2.1.8 Байгальд ээлтэй, хаягдал бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих, урамшуулах

2.1.9 Аюултай хог хаягдлыг түр байршуулах газрыг байгаль орчин, эрүүл мэндийн зэрэг холбогдох мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийг үндэслэн тогтоож, түр хадгалах байр, түүнийг тээвэрлэх зам маршрут гарган батлах.

2.1.10 Гэр хороололд болон хог хаягдал хадгалах зориулалтын байгууламжгүй орон сууцанд оршин суугч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал хадгалах түр цэг тогтоох.

2.1.11 Сумын айл өрх, аж ахуй нэгж байгууллага, худалдаа үйлчилгээний цэг салбар бүрийг хог хаягдлын дэвтэртэй болгох

2.1.12 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сар бүр төлөөгүй иргэн, аж ахуйн нэгж байгууллага, худалдаа үйлчилгээний цэг салбаруудад хариуцлага тооцож ажиллах

2.1.13 Хог хаягдлын үйлчилгээний дэвтрийн загварыг батлах

2.1.14 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төсөвт төвлөрүүлэх ажлыг удирдан зохион байгуулах

2.2 **Багийн Засаг даргын хүлээх үүрэг:**

2.2.1 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах, үйл ажиллагаанд хяналт тавих, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хог хаягдлыг бууруулах, ангилах, эргүүлэн ашиглах, дахин боловсруулах мэдээлэл сургалтыг тогтмол зохион байгуулах.

3.2.2 Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх аюултай хог хаягдал ил задгай хаясан, шатаасан иргэн, байгууллагыг тогтоон, улсын байцаагчид мэдээллэх, хариуцлага хүлээлгэх, дахин ил задгай талбайд хог үүсгэхгүй байхад хяналт тавих.

3.2.3 Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллагын тээвэрлэлтийн график, хугацаа, давтамжинд хяналт тавьж, хамтран ажиллах.

3.2.4 Нийтийг хамарсан цэвэрлэгээ зохион байгуулахад иргэдийг оролцуулах,

3.2.5 Төв сууринга ас алслагдсан хэсэг, бүлэг айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллах.

3.2.6 Хог хаягдлын дэвтрийг иргэн аж ахуйн нэгж байгууллага, худалдаа үйлчилгээний цэгүүдэд хүргэж, Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, эргүүлэн ашиглах, устгах, санхүүжүүлэх, журмыг сурталчилж ажиллах

3.3 Байгууллага, аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээний цэгийн хүлээх үүрэг:

3.3.1 Мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авах;

3.3.2 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилж, цуглуулах, тээвэрлэх хог хаягдлын хэсэгт батлагдсан хуваарийн дагуу хүлээлгэн өгөх.

3.3.3 Эмнэлгийн болон барилгын хог хаягдлыг тухайн салбарын байгууллагаас батлагдсан журмын дагуу устгах.

3.3.4 Сар бүр хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төлж дэвтэр дээр сар бүр бичилт хийлгэх

3.3.5 Сар бүрийн 15-ны дотор хог хаягдлын үйлчилгээний хураамжийг .....банкин дахь..... тоот дансанд төлөх буюу эрх бүхий этгээдэд төлнө.

3.4 Айл өрхийн хүлээх үүрэг:

3.4.1 Хог хаягдлаа ангилан, зориулалтын савand хадгалж, батлагдсан хуваарийн дагуу хог хаягдал цуглуулах тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэн өгөх.

3.4.2 Зориулалтын цэгээс бусад цэгт хог хаяхгүй, хог шатаахгүй байх.

3.4.2 Айл өрх бүр нийгмийн хариуцлагаа ухамсарлан сар бүр хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төлөх

3.4.3 Хог хаягдлын дэвтэрт бичилт хийлгэх сар бүрийн 15-ны дотор хог хаягдлын үйлчилгээний хураамжийг..... банкин .....тоот дансанд төлөх бүюу эрх бүхий этгээдэд төлнө.

3.5 Хог хаягдлын менежментийн хэсгийн хүлээх үүрэг:

3.5.1 Хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах хуваарийг гарган батлуулах

3.5.2 Иргэдийн гомдлыг бүрэн барагдуулж батлагдсан хуваарийн дагуу доголдолгүй ажиллах.

3.5.3 Ил задгай хог асгасан иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг эрх бүхий улсын байцаагч харъяалах Засаг даргад үнэн зөв мэдээлэх, зөрчлийг арилгахад хамтран ажиллах

3.5.4 Хог хаягдлын тайлан мэдээг сар бүр гарган тайлагнах.

3.5.5 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сар бүрийн 25-ны дотор төсөвт төвлөрүүлж хог хаягдлыг тээвэрлэх, дарж булах

3.5.6 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сар бүр төлөхийг айл өрх, худалдаа үйлчилгээний цэг салбар, аж ахуйн нэгж, байгууллагаас шаардах

3.6 Олон нийтийн байцаагч / цагдаагийн ажилтан /- ийн хүлээх эрх үүрэг

3.6.1 Хог хаягдлын тухай хууль тогтоомжоор тогтоосон захиргааны үүргийн биелэлтэнд хяналт тавих

3.6.2 Иргэд аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлаа зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд хяналт тавьж, зөрчсөн этгээдэд арга хэмжээ авах, эрх бүхий албан тушаалтанд мэдээлэх

3.6.3 Нийтийг хамарсан цэвэрлэгээ зохион байгуулахад иргэдийг татан оролцуулахад багийн Засаг даргатай хамтран ажиллах

3.6.4 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төсөвт төвлөрүүлэх ажлыг ТХГ-ын хэсэг, багийн Засаг дарга, нартай хамтран зохион байгуулах

Дөрөв. Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, эргүүлэх ашиглах , устгах

4.1 Хог хаягдлыг ангилан ялгах

4.1.1 Сум суурин газар оршин сууж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдлыг заасан зориулалтын цэгт ангилан ялгаж хаях

4.1.2 Зориулалтын цэгээс бусад газар хог хаягдал хаяхгүй байх

4.1.3 Сум суурин газрын оршин суугч нь тусгай зориулалтын хогийн сав болон хог тээвэрлэх зориулалт бүхий машин ирэх хуваарийн дагуу хог хаягдлыг хаях

4.1.4 Төв суурин газар, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, сургууль, цэцэрлэг, аж ахуй нэгжүүдэд хатуу хог хаягдлыг ангилан ялгадаг хогийн савыг ашиглах

4.1.5 "Бусад хог" хаягдал

- Биологийн болон хүнсний гаралтай хог хаягдал
- Барилгын гаралтай хог хаягдал
- Бусад төрлийн хог хаягдал

4.2 Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх эргуулэн ашиглах

4.2.1 Хог тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь зориулалтын болон аюулгүй ажиллагааг хангасан битүүмжилсэн байх

4.2.2 Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх бүлах бүх үйл ажиллагаанд бүртгэл тэмдэглэлийг хөтөлнө Бүртгэл нь 2 хувь хөтлөгдөх ба нэг хувь хогийн төвлөрсөн цэгийн харуулд нөгөө нь тээвэрлэлт бүлалт хийсэн ажилтанд байх

4.2.3 Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, байгууллага нь хүрээлэн бүй орчин, хөрсийг бохирдуулахгүй байх

4.2.4 Аюултай хог хаягдлыг ахүйн гаралтай хог хаягдлаас тусад нь савлан цуглуулж, тээвэрлэж дууссан даруй тээврийн хэрэгслийг тухайн хариуцагч аюулгүй, хоргүй халдваргүй болгох арга хэмжээ авна. Тээвэрлэх үедээ тээврийн хэрэгсэл нь тусгай сэрэмжлүүлэг тэмдэгтэй байх.

4.2.5 Баг бүр хоёдогч түүхий эд авах цэг бий болгох

4.3 Хог хаягдлыг булах устгах

4.3.1 Хог хаягдлыг устгах эрх бүхий иргэн, аж ахүйн нэгж байгууллага нь эргүүлэн ашиглах боломжгүй хог хаягдлыг цуглуулж, төвлөрсөн хогийн цэгт хүргэн ландфиллийн аргаар устгах

4.3.2 Аюултай хог хаягдлыг аюулгүй болгох, хадгалах, устгахад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн бусад баримт бичиг, стандарт норм, нормативыг мөрдөнө.

4.3.3 Эмнэлгийн гаралтай болон аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ариутган халдваргүйжүүлсэн тохиолдолд хогийн төвлөрсөн цэгт хүлээн авч, тусгай байгууламжинд хаях

Тав. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх

5.1 Хог хаягдлын орлого нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ.

5.1.1 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батална.

5.1.2 Иргэн, аж ахүйн нэгж, төсөвт байгууллага, худалдаа үйлчилгээний цэг салбар, гадаад дотоодын амрагч жуулчдын хог хаягдлын үйлчилгээний хураамж.

5.1.3 Олон улсын бөлон өөрийн орны иргэд, аж ахүйн нэгж, байгууллагын хандив тусламж

5.1.4 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ

5.2 Хог хаягдлын орлогыг зарцуулах

5.2.1 Хог хаягдлын тухай хуулийн 20.3-д заасны дагуу төсвийн тухай хуулийн хүрээнд зохицуулалт хийж, сумын ИТХ-ын шийдвэрээр хог хаягдал тээвэрлэх, устгах тэдгээртэй холбогдох зардалд зарцуулна.

5.2.2 Хог хаягдлыг багасгахад чиглэгдсэн бусад арга хэмжээ

5.2.3 Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахүйн нэгж байгууллагад олгох үйл ажиллагааны зардлыг тухайн гэрээнд тодорхой тусгана.

5.2.4 Хог ахягдалын талаар сургалт суртачилгаа хийх, гарын авлага тараах

5.3 Хог хаягдлыг багасгахад оролцогчдод үзүүлэх урамшуулал

5.3.1 Засгийн газраас баталсан урамшуулал үзүүлэх журмын дагуу хог хаягдал анхан шатанд нь ялгаж хэвшсэн бууруулахад шинэ санаачлага гаргасан, хоёрдогч түүхий эдийг цуглуулах дахин боловсруулах арга технологийг нэвтрүүлэх, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн аж ахуйн нэгж, байгууллагыг сурталчилж, урамшуулал олгоно.

Зургаа. Хориглох зүйлс

6.1 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ил задгай газар ахуйн хог, үнс, малын гаралтай хог, барилгын болон эмнэлгийн гаралтай хаягдал хаях, шатаахыг хориглох

6.2 Хүн ам төвлөрөн суурьшсан бүс, ундны эх үүсвэр болон эрүүл ахуйн бүс, ашигт малтмалын нөөц нь тогтоогдсон газарт хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулахыг хориглох.

6.3 Худалдаа үйлчилгээнд 0,025мм болон бага зузаантай хальсан уут хэрэглэхийг хориглох

Долоо. Хог хаягдлын үйл ажиллагаа, төвлөрсөн хөрөнгийн орлого, зарцуулалтыг тайлагнах, мэдээллэх

7.1 Хог хаягдалтай холбогдох үйл ажиллагааны тайланг Тосгоны хэмжээнд жилийн эцсийн байдлаар нэгтгэн, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах

7.2 Журмын 7.1-д заасан хурлын дүгнэлтийг иргэний танхим болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх

7.3 Энэхүү журмыг нийтэд мэдээлэх, сурталчлах зорилгоор гарын авлага тараах

Найм. Хог хаягдалтай холбогдолтой үйл ажиллагаанд хяналт тавих

8.1 Хог хаягдалтай холбогдох журмын хэрэгжилтэнд бүх шатны Засаг дарга, Байгаль орчны хяналтын байцаагч, Олон нийтийн байцаагч, Байгаль хамгаалагч, Цагдаагийн ажилтан нар хяналт тавина.

8.2 Хог хаягдлын үйлчилгээний хураамжаас төсөвт төвлөрсөн орлого, зарцуулалтын байдалд эрх бүхий улсын байцаагч нар хяналт тавьж ажиллана

8.3 Иргэд, төрийн бус байгууллага хуулиар тогтоосон эрх хэмжээний хүрээнд энэхүү журмын биелэлтэнд хөндлөнгийн хяналт тавьж, зөрчлийг арилгуулах талаар санал, хүсэлтээ холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж болно.

Ес. Хариуцлага хүлээлгэх

9.1 Хог хаягдлын тухай хуулийн 23-р зүйлийн дагуу хариуцлага хүлээлгэх

9.2 Хууль журмаар заасан албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан төрийн албан хаагчийг эсэргүүцсэн биед нь халдсан зэрэг зөрчил гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны хэргийн тухай хуулиар шийтгэл ногдуулна.

ЖУРАМ БОЛОВСРУУЛСАН: БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ

Х.ХИШИГЖАРГАЛ